

**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА  
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**



**ХОВД АЙМГИЙН 2021 ОНЫ  
ТӨСВИЙН ТӨСӨЛД ӨГСӨН  
АУДИТЫН ДҮГНЭЛТ**

**Ховд хот**

**2020 оны 11 сар**

## АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ .....	3
НЭГ.ЕРӨНХИЙ ЗҮЙЛ .....	4
ХОЁР. ХОВД АЙМГИЙН 2021 ОНЫ ТӨСВИЙН НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖ .....	5
ГУРАВ. ХОВД АЙМГИЙН 2021 ОНЫ ТӨСВИЙН НИЙТ ЗАРЛАГА .....	6
ДӨРӨВ. ОРОН НУТГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САН, ТУСГАЙ САНГУУД.....	6-9

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

<b>ҮАГ</b>	Үндэсний Аудитын газар
<b>ИТХ</b>	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
<b>ОНХС</b>	Орон нутгийн хөгжлийн сан
<b>ОНХО</b>	Орон нутгийн хөрөнгө оруулалт
<b>СХС</b>	Сум хөгжүүлэх сан
<b>ТАХ</b>	Төсөл арга хэмжээ
<b>АМНАТ</b>	Ашигт малтмалын нөөц ашигласны татвар
<b>ТЗШ</b>	Тусгай зориулалтын шилжүүлэг
<b>ЗД</b>	Засаг дарга

## ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Аймгийн Засаг даргаас Иргэдийн Төлөөлөгчдийн хуралд өргөн мэдүүлсэн Ховд аймгийн 2021 оны төсвийн төсөлд Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2-д "... аймаг, нийслэлийн Засаг даргаас тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлсэн жилийн төсвийн төсөлд орлого нэмэгдүүлэх, зарлагыг бууруулах, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх талаар дүгнэлт гаргаж, Улсын Их Хурал болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүргүүлэх", Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5.1-д "аймаг, нийслэлийн Засаг дарга тухайн шатны жилийн төсвийн төслийг жил бүрийн 11 дүгээр сарын 20-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, 11 дүгээр сарын 25-ны дотор тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх" гэж тус тус заасны дагуу Ховд аймаг дахь Төрийн аудитын газраас Ховд аймгийн 2021 оны төсвийн төслийн талаарх дүгнэлт гаргалаа.

Гэвч Ховд аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр шинээр боловсруулагдан батлагдсантай уялдуулан төлөвлөгөө хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээг аймгийн 2021 оны төсвийн төсөлд тусгах зэрэгтэй холбогдон удааширч хуульд заасан хугацаанаас 10 хоног хугацаа хэтэрч ирсэн нь аудитын дүгнэлтийг гаргах цаг хугацаа богино байлаа.

Энэхүү дүгнэлтийг гаргахдаа Төсвийн тогтвортой байдлын тухай, Төсвийн тухай, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай зэрэг хуулиудын холбогдох зүйл, заалт, "Ховд аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай", "Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай" Аймгийн ИТХ-ын 2020 оны 11 дүгээр сарын 24-ны өдрийн 2/04, 2/05 тоот тогтоол зэрэг холбогдох эрх зүйн актыг шалгуур үзүүлэлт болгов. Тухайлбал:

1. "Ховд аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай", "Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-т тусгасан зорилт, арга хэмжээтэй уялдсан эсэх;
2. Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт нь төсөвлөлтийн шаардлагад нийцсэн эсэх.

Ховд аймгийн 2021 оны төсвийн төслийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилтуудаас 2021 онд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг төлөвлөж, коронавируст халдвар /Ковид-19/ цар тахлын онцгой нөхцөлд байдалд төсвийн орлогыг бүрдүүлэх, зарлагыг хэмнэх бодлого баримтлан боловсруулсан байна.

## **ХОЁР. ХОВД АЙМГИЙН 2021 ОНЫ ТӨСВИЙН НИЙТ ОРЛОГО**

Аймгийн Засаг дарга бөгөөд төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны орон нутгийн нэгдсэн орлогыг Сангийн яам 81871.5 сая төгрөг байхаар хянаж ирүүлжээ.

Аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс Сангийн яамнаас хянагдаж ирсэн суурь нэгдсэн орлогыг 85356.0 сая төгрөг байхаар нэгтгэж, 3484.5 сая төгрөгөөр нэмэгдүүлэхээр аймгийн ИТХ-д санал оруулсан байна. Үүнд: аймаг, сумдын татварын орлогыг 784.3 сая, ТЗШ-ын орлогыг 131.7 сая, өмнөх оны үлдэгдлээс 426.6 сая, хяналтын орлогоос 120.0 сая, цэргийн дүйцүүлэхийн орлогоос 20.0 сая, Хөшөөт хөгжил санг 2001.8 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн байна.

2021 оны орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг 2020 оны төсвийн орлогын төлөвлөгөөтэй харьцуулахад 51.2 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн бол 2020 оны хүлээгдэж буй гүйцэтгэлтэй харьцуулахад 1633.4 сая төгрөгөөр бууруулсан байна.

2020 оны хүлээгдэж байгаа гүйцэтгэлээс татварын орлогыг 1.1 сая, нийт орлогыг 1493.9 сая, тусламжийн орлогыг 1883.4 сая, ОНХС-гийн орлогыг 3115.2 сая, Хөшөөт хөгжлийн сангийн орлогыг 2001.8 сая, авлагаас орох орлогыг 140.0 сая төгрөгөөр өсгөж урд оны үлдэгдлээс санхүүжих орлогыг 4300.7 сая төгрөгөөр, санхүүгийн дэмжлэгийг 2486.8 сая, ТЗШ-ыг 746.8 сая, СХС-гийн эргэн төлөлтийг 850.0 сая төгрөгөөр бууруулан төлөвлөжээ.

Ховд аймгийн 2021 оны төсвийн төсөлд зарим эх үүсвэрийг дайчлан орлого нэмэгдүүлэх боломж байна. Үүнд:

- 2.1 Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн 6-р зүйлийн 6.1-д нэг малын тоо толгойд тухайн татварын жилд ногдуулах албан татварын хэмжээ нь 0-2000 төгрөг байна гэж заасныг бог, бод малын итгэлцүүрээр тооцон 2019 онд тоологдсон 3.1 сая толгой малын тоонд үндэслэн 80 хувиар тооцож орлогыг сумдын ИТХ-д чиглэл өгч, сумдын 2021 оны төсөвт тусган төлөвлөх шаардлагатай байна.
- 2.2 Мал бүхий иргэн, хуулийн этгээдээс төв суурин газарт борлуулах зорилгоор оруулж байгаа олон тооны мал, мах бэлтгэхэд гарал үүслийн гэрчилгээг Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 35-р зүйлийн 35.1.14 дэх заалтын дагуу олгож орон нутгийн төсвийн орлогыг нэмэгдүүлэх нөөц боломж байна.
- 2.3 Газрын төлбөрийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2-т газрын төлбөрийн төлөх хугацааг, 10 дугаар зүйлийн 10.1-т газрын төлбөрийг орон нутгийн орлого болохыг зааж өгсөн байна. Төсвийн тухай хуульд сумын төсвийн орлогод газрын төлбөрийн 40 хувийг төвлөрүүлэх талаар нэмэлт өөрчлөлт орсон бөгөөд 2021 онд газрын төлбөрийн орлогоор 340.7 сая төгрөг бүрдэхээр төлөвлөсөн ч аймаг, сумдын газрын даамлууд газрын төлбөрийн ногдуулалт хийж төлбөрийг төвлөрүүлдэггүй дутагдал илэрч, өмнөх онуудын газрын төлбөрийн ногдуулалтыг төлөхгүй байсаар байна.

***Дүгнэлт: Дээрх тооцоо судалгаанд үндэслэн малын хөлийн татварын орлогыг сумдын орлогод төлөвлөх чиглэл өгч хэрэгжүүлэх орон нутгийн орлогын нөөцийг дайчлах боломжтой байна.***

## ГУРАВ. ХОВД АЙМГИЙН 2021 ОНЫ ТӨСВИЙН НИЙТ ЗАРЛАГА

Аймгийн 2021 оны төсвийн зарлагыг 85356.0 сая төгрөг байхаар тооцсон нь 2020 оны төлөвлөгөөнөөс 51.8 сая тэрбум төгрөгийн өсөлттэй төлөвлөгджээ.

Орон нутгийн байгууллагуудын удирдлагыг хэрэгжүүлэх зардалд 21131.1 сая, тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын төсвийн зардалд 48258.4 сая, орон нутгийн хөрөнгө оруулалт 1245.5 сая, ОНХС-д 12719.2 сая, Хөшөөт хөгжлийн санд 2001.8 сая төгрөг тус тус хуваарилсан.

Аймгийн хөгжлийн 2021-2025 оны үндсэн чиглэл, Засгийн газрын болон аймаг сумдын засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, төсөвт байгууллагуудын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан 2021 оны бодлого зорилтыг хэрэгжүүлэхэд шаардагдах эх үүсвэрийг санхүүжүүлэх зориулан зардлыг төлөвлөсөн байна.

Коронавирус цар тахлын үеийн нөхцөл байдал үүссэн үед орон нутгийн төсвийн зарлагыг санхүүжүүлэх орлогын эх үүсвэр хүрэлцэхгүй байх, зарим нэр төрлийн зардлын хооронд зохицуулалт хийх зэрэг нөхцөл байдал үүсэж болзошгүй тул зардлыг бууруулах талаар санал дүгнэлт оруулаагүй болно.

*Гэвч нийтийг хамарсан цар тахлын эрсдэл бүхий нөхцөлд 2021 оны төсвийн төсөл боловсруулагдсан, төсвийн орлогыг бүрдүүлэхэд хүндрэлтэй байгаа үед эрүүл мэндийн болон гамшгийн онцгой нөхцөлд ажилладаг байгууллагуудаас бусад байгууллагуудад эд хогшил, тээвэр шатахуун, томилолт, зочин төлөөлөгчдийн зардал зэрэг төсөв захирагчдын тэвчиж болох зардлуудыг санхүүжүүлэхгүй байх зарчмыг баримтлан ажиллах шаардлагатай байна.*

### **ДӨРӨВ: ОРОН НУТГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ОНХС, ТУСГАЙ САНГУУД:**

Аймгийн хөрөнгө оруулалт, ОНХС, тусгай сангуудын хөрөнгөөр нийт 30452.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 11404.4 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 175 хөтөлбөр, төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр төсөвлөсөн байна. /сая төгрөгөөр/

Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал байршил	Тоо хэмжээ	Төсөвт өртөг	2021 онд санхүүжих нийт дүн
Орон нутгийн хөрөнгө оруулалт	2	530.0	230.0
Орон нутгийн хөгжлийн сан	108	26,073.6	8,408.7
Замын сан	12	1,185.0	595.0
Байгаль хамгаалах сан	3	165.5	120.5
Хөшөөт хөгжлийн сан	50	2,498.0	2,050.2
<b>НИЙТ ДҮН</b>	<b>175.0</b>	<b>30,452.1</b>	<b>11,404.4</b>

Ховд аймгийн 2021 оны төсвийн төсөлд тусгагдсан хөрөнгө оруулалтын ажлуудыг хянахад дараах алдаа зөрчлийг арилган төлөвлөх шаардлагатай байна. Үүнд:

4.1 Аймгийн хөрөнгө оруулалт, ОНХС, тусгай сангуудын 2021 оны төсвийн төсөлд шинээр хэрэгжүүлэх 97 хөрөнгө оруулалтад 5627.5 сая төгрөг төлөвлөснөөс Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4-т заасныг зөрчиж зураг төсөвгүй, төсөвлөлтийн шаардлага хангаагүй байхад 59.9 хувь буюу 66 төсөл арга хэмжээнд 3372.6 сая төгрөг зарцуулахаар төлөвлөжээ. Хүснэгтээр үзүүлбэл/ сая.төг/

Байгууллага	Төсөл, арга хэмжээний нэр	Нийт төлөвлөгдсөн		Зураг, төсөвт өртгийн тооцоололтой		Зураг, төсөвт өртгийн тооцоололгүй	
		Тоо хэмжээ	2021 онд санхүүжих	Тоо хэмжээ	2021 онд санхүүжих	Тоо хэмжээ	2021 онд санхүүжих
ОНХС	II. Шинээр эхлэх хөрөнгө оруулалт, их засвар	57	3,970.0	27	2,045.9	30	1,924.1
Замын сан	II. Шинээр эхлэх хөрөнгө оруулалт, их засвар	10	480.0			10	480.0
БХС	II. Шинээр эхлэх хөрөнгө оруулалт, их засвар	2	105.5			2	105.5
Хөшөөт хөгжил сан	II. Шинээр эхлэх хөрөнгө оруулалт, тоног төхөөрөмж, их засвар	28	1,072.0	4	209.0	24	863.0
<b>ДҮН</b>		<b>97</b>	<b>5,627.5</b>	<b>31</b>	<b>2,254.9</b>	<b>66</b>	<b>3,372.6</b>

4.2 Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас аймгийн орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийг 12294.6 сая төгрөг байхаар төлөвлөсөн нь өмнөх оноос 6234.3 сая төгрөгөөр буюу 2 дахин өссөн байна. Үүнээс 30 хувь буюу 3885.8 сая төгрөгийг сумдын ОНХС-д, 70 хувь буюу 8408.7 сая төгрөгийг аймгийн ОНХС хуваарилахаар төлөвлөжээ. Аймгийн ОНХС-гийн эх үүсвэрт АМНАТ-ын 5430.3 сая төгрөгийн эх үүсвэр хуваарилагдаж, үүнээс Дарви сумын ОНХС-д 1142.0 сая төгрөгийг хуваарилсан нь Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, ашиглалтын болон Хайгуулын тусгай зөвшөөрлийн орлогоос орон нутгийн хөгжлийн санд олгох шилжүүлэг тооцох аргачлалын 3.2.1<sup>1</sup>-д заасны дагуу тооцоход 650.0 сая төгрөгийг дутуу байна.

4.4 “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 3 дугаар зүйлийн 3.1<sup>2</sup>, 7 дугаар зүйлийн 7.2-т заасан шаардлага хангаагүй, батлагдаагүй 28 хөтөлбөр арга хэмжээнд 3169.5 сая төгрөгийг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн нь нийт төсвийн 37.6 хувийг эзэлж байна. Гэвч нэн шаардлагатай, тэргүүлэх ач холбогдол бүхий хөтөлбөрүүдийг багцаар хэрэгжүүлж, хөтөлбөрийн тоо болон санхүүжилтийг бууруулан ОНХС-гийн журамтай нийцүүлэх шаардлагатай байна.

4.3 Хөрөнгө оруулалтын төлөвлөлтийг үзэхэд байршил зураг нь тодорхойгүй, мөн төсөл арга хэмжээг багцалж төлөвлөөгүй, хэрэгжүүлэх ажлын задаргаагүй, тооцоо судалгаагүй зэрэг зөрчлүүд давтагдсаар байгаа ба холбогдох журамд

<sup>1</sup> Аймаг, нийслэлийн орон нутгийн хөгжлийн сан нь энэ аргачлалын 3.1.1-д заасан орлогын 33-аас доошгүй хувийг ашигт малтмалын олборлолт хийсэн сум, дүүргийн орон нутгийн хөгжлийн санд олгоно.”

<sup>2</sup> ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэхэд дараах нөхцөлүүдийг хангасан байна

нийцүүлэн төсвийн бодит тооцоолол хийж, төсвийг бууруулах шаардлагатай байна. Тухайлбал:

- Нийтийн орон сууцанд дулааны улиралд хэрэглээний халуун ус өгөх ажлын 400.0 сая, түүхт ойг угтаж хийх ажил, арга хэмжээний зардалд 1800.0 сая, жишиг гудамжны 748.0 сая төгрөгийн төсвийн тооцоолол тодорхой бус,
- 7 байршилд байгаа 626.0 сая төгрөгийн төсөвтэй гудамжны гэрэлтүүлэгт, 190.0 сая төгрөгийн 6 ухаалаг худгуудыг нэг загварын зургаар төсөвлөж, багц хэлбэрээр төсөвт тусгаагүй, зураг төсөвгүй байна.

4.4 Аймгийн түвшинд ОНХСан-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл арга хэмжээг ОНХСангийн үйл ажиллагааны 228 дугаар журмын 7-р зүйлийн 7.2<sup>3</sup>-т заасны дагуу журмын хэрэгжилтийг хангаж ажиллаагүй байна. Аймгийн ОНХС-ийн төлөвлөлттэй холбогдох үйл ажиллагаа нь тус сангийн үйл ажиллагааны журамд нийцээгүй байна. Иймд сумдаас ирүүлсэн саналын эрэмбэ, хэрэгцээнд үндэслэн ард иргэдийн хүлээлт үүсгэсэн хөрөнгө оруулалтын ажлуудыг тусгаж, төлөөлөгчдийн хүсэлт, сонирхолд нийцүүлж төлөвлөдөг дутагдлыг арилгах шаардлагатай байна.

4.5 2019 онд ОНХС-гийн эх үүсвэрээр хэрэгжүүлсэн 400.0 сая төгрөгийн өртөгтэй үйлдвэрлэлийг дэмжих зээлийн эх үүсвэр нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3.5<sup>4</sup>, ОНХсан-ийн үйл ажиллагааны журмын 4-р зүйлийн 4.2.4<sup>5</sup>, 3-р зүйлийн 3.1.2<sup>6</sup> дах заалттай нийцэхгүй байгаа ба Төрийн аудитын байгууллагаас зээлийг буцаан төвлөрүүлж, ОНХС-гийн эх үүсвэр болгох албан шаардлага бичсэн тул хэрэгжилтийг ханган эх үүсвэрийг нэмэгдүүлэн төлөвлөх бололцоотой байна.

4.6 Жаргалант сумын 1 дүгээр сургуулийн эдэлбэр газрыг аймгийн Засаг даргын 2019 оны А/230 тоот захирамжаар газрын ашиглалтын зориулалтыг өөрчилсөн нь Боловсролын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.5<sup>7</sup>, 42.7<sup>8</sup>, 42.8<sup>9</sup> дахь заалтуудтай нийцэхгүй байхад багш нарын байрны буулгалтын зардалд 59.0 сая төгрөг төсөвлөсөн байна.

4.7 Хөшөөт хөгжил сан байгуулан төлөвлөж зарцуулж байгаа нь Засгийн газрын тусгай сангийн тухай хуультай нийцэхгүй байгаа талаар өмнө онуудад хийгдсэн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэхгүй, алдаа зөрчил давтагдсаар байна.

4.8 Сумдын 2020 оны тодотгосон төсөвт тусгаснаар 1168.4 сая төгрөгийн орлогод тусгаж зарцуулахаар тусгагдсан байна. Сум хөгжүүлэх сангийн эх үүсвэрийг

<sup>3</sup> Ажлын хэсэг аймаг, нийслэлийн ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний урьдчилсан жагсаалтыг дараах үзүүлэлтүүдийг харгалзан үзэж боловсруулна

<sup>4</sup> зээл олгох, санхүүгийн үр дагавар бүхий баталгаа гаргах, хохирлыг нөхөн төлөх үүрэг авах;

<sup>5</sup> Аливаа аж ахуйн нэгж, байгууллага, иргэнд олгох буцалтгүй тусламж, дэмжлэг, тэтгэмж, урамшуулал;

<sup>6</sup> ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь тухайн орон нутгийн иргэдийн саналаар дэмжигдэж эрэмбэлэгдсэн байх

<sup>7</sup> "Боловсролын сургалтын байгууллагын барилга байгууламж, эдэлбэр газрыг зориулалтын дагуу ашиглана"

<sup>8</sup> 42.7.Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь шинээр барих сургууль, цэцэрлэгийн урт хугацааны төлөвлөлтийг аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө, хотын хөгжлийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд тусгаж, сургууль, цэцэрлэгийн эзэмшил, ашиглалтын эдэлбэр газрыг сургалтын орчинд тавигдах шаардлагад нийцсэн талбайн хэмжээний дагуу нөөцөд авах шийдвэр гаргана.

<sup>9</sup> 42.8.Энэ хуулийн 42.7-д заасны дагуу шинээр барих сургууль, цэцэрлэгийн нөөцийн газрыг өөр зориулалтаар эзэмшүүлэх, ашиглуулах, худалдахыг хориглоно.



бодиттой төлөвлөж, зээлийн эргэн төлөлтөд тавих бүх шатны хяналтыг сайжруулан зээлийн эргэц нэмэгдүүлэх шаардлагатай байна.

**ДҮГНЭЛТ:**

- Хөрөнгө оруулалтыг хөгжлийн бодлого төлөвлөлтийн нэгдмэл, цогц, харилцан уялдаатай байх зарчимд нийцүүлэн нэг загварын зураг, төсвөөр төсөвлөх бололцоотой хөтөлбөрүүдийг нэгтгэн багцалж, хөтөлбөр хэрэгжүүлэх нөхцөл шаардлага, тооцоо судалгаа, хүрэх үр дүн, өгөөж, төсвийн тооцоолол зэргийг үндэслэн үе шаттайгаар цогц байдлаар хэрэгжүүлэхээр төлөвлөх шаардлагатай байна.
- Төсвийн төсөлд зураг төсөвгүй, төсөвлөлтийн шаардлага хангаагүй, зах зээлийн үнэлгээ хийгдээгүй төсөл, арга хэмжээг тусгасан нь төсөл, арга хэмжээний төсвийн хөрөнгийн үр ашиг буурах, хуулийн хэрэгжилт хангагдахгүй байх нөхцөл бүрдсэн тул зөрчлийг арилган төлөвлөх
- Иргэдийн саналд үндэслэсэн, бүс нутгийн онцлогт нийцсэн үйлдвэрлэлийн салбарыг дэмжин иргэдийн ая тухтай, тогтвор суурьшилтай амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлэхэд хөрөнгө оруулалтуудын чиглүүлэн хэрэгжүүлэх.
- Сум хөгжүүлэх сангийн төсөвлөлтийг бодитой төлөвлөх .
- Хөшөөт хөгжил сан байгуулан зарцуулж байгаа нь Засгийн газрын тусгай сангийн тухай хуультай нийцэхгүй байгаа тул төлөвлөсөн хөрөнгийн эх үүсвэрийг ОНХС-гийн эх үүсвэр болгон төлөвлөх шаардлагатай.

**ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ:**

**ОРОН НУТГИЙН ОРЛОГЫГ НЭМЭГДҮҮЛЭН, ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНҮҮДИЙН ТӨСВИЙГ ХУУЛЬ, ЖУРАМД НИЙЦҮҮЛЭН ОНОВЧТОЙ, ҮР АШИГТАЙ ТӨЛӨВЛӨХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.**

**ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**